| 210203 | ҮОМШӨ-ний даатгал                                         | 2,559,700.00   | 2,462,663.95                | 97,036.05       | 96.2%  |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал                                      | 2,559,700.00   | 2,318,059.61                | 241,640.39      | 90.6%  |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал                                     | 10,238,700.00  | 9,272,238.40                | 966,461.60      | 90.6%  |
| 2104   | Хангамж, бараа материалын зардал                          | 10,363,000.00  | 10,362,901.61               | 98.39           | 100.0% |
| 210401 | Бичиг хэрэг                                               | 1,781,600.00   | 1,722,950.00                | 58,650.00       | 96.7%  |
| 210402 | Тээвэр, шатахуун                                          | 2,452,500.00   | 2,746,250.00                | -293,750.00     | 112.0% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                        | 2,106,800.00   | 1,684,101.61                | 422,698.39      | 79.9%  |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 588,600.00     | 420,000.00                  | 168,600.00      | 71.4%  |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс               | 3,433,500.00   | 3,789,600.00                | -356,100.00     | 110.4% |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                         | 5,689,800.00   | 5,689,000.00                | 800.00          | 100.0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл                                   | 5,689,800.00   | 5,689,000.00                | 800.00          | 100.0% |
| 2107   | Томилолт, зочны зардал                                    | 3,433,500.00   | 3,390,000.00                | 43,500.00       | 98.7%  |
| 210702 | Дотоод албан томилолт                                     | 3,433,500.00   | 3,390,000.00                | 43,500.00       | 98.7%  |
| 2108   | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж  | 6,531,700.00   | 6,041,290.00                | 490,410.00      | 92.5%  |

|        |                                                                                       |                       |                       |                      |               |
|--------|---------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|----------------------|---------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                  | 1,452,500.00          | 1,327,840.00          | 124,660.00           | 91.4%         |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                              | 876,000.00            | 876,000.00            | 0.00                 | 100.0%        |
| 210803 | Даатгалын үйлчилгээ                                                                   | 201,400.00            | 119,250.00            | 82,150.00            | 59.2%         |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар                                                            | 245,200.00            | 137,000.00            | 108,200.00           | 55.9%         |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                                         | 107,900.00            | 00.00                 | 107,900.00           | 0.0%          |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                                       | 490,500.00            | 423,000.00            | 67,500.00            | 86.2%         |
| 210807 | Газрын төлбөр                                                                         | 3,158,200.00          | 3,158,200.00          | 0.00                 | 100.0%        |
| 2109   | Бараа үйлчилгээний бусад зардал                                                       | 129,340,300.00        | 129,310,300.00        | 30,000.00            | 100.0%        |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                                       | 129,340,300.00        | 129,310,300.00        | 30,000.00            | 100.0%        |
| 213    | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                                                      | 27,857,600.00         | 27,856,103.00         | 1497.00              | 100%          |
| 2132   | Бусад урсгал шилжүүлэг                                                                | 27,857,600.00         | 27,856,103.00         | 1,497.00             | 100.0%        |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                                   | 17,732,800.00         | 17,732,131.00         | 669.00               | 100.0%        |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,038,000.00          | 8,037,972.00          | 28.00                | 100.0%        |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                               | 2,086,800.00          | 2,086,000.00          | 800.00               | 100.0%        |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                 | <b>759,145,300.00</b> | <b>736,925,990.78</b> | <b>22,219,309.22</b> | <b>97.1%</b>  |
| 1310   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                                        | <b>759,145,300.00</b> | <b>736,925,990.78</b> | <b>22,219,309.22</b> | <b>97.1%</b>  |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих                                                               | 759,145,300.00        | 736,925,990.78        | 22,219,309.22        | 97.1%         |
| 61     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                                               | <b>01.00</b>          | <b>01.00</b>          | <b>0.00</b>          | <b>100.0%</b> |
| 610001 | Төсвийн байгууллага                                                                   | 01.00                 | 01.00                 | 0.00                 | 100.0%        |
| 62     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                                                               | <b>23.00</b>          | <b>25.00</b>          | <b>-2.00</b>         | <b>108.7%</b> |
| 620001 | Удирдах ажилтан                                                                       | 01.00                 | 01.00                 | 0.00                 | 100.0%        |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан                                                                     | 09.00                 | 11.00                 | -2.00                | 122.2%        |
| 620003 | Үйлчлэх ажилтан                                                                       | 09.00                 | 09.00                 | 0.00                 | 100.0%        |
| 620004 | Гэрээт ажилтан                                                                        | 04.00                 | 04.00                 | 0.00                 | 100.0%        |
| 65     | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                                            | <b>23.00</b>          | <b>25.00</b>          | <b>-2.00</b>         | <b>108.7%</b> |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                                                    | 03.00                 | 03.00                 | 0.00                 | 100.0%        |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                                            | 16.00                 | 18.00                 | -2.00                | 112.5%        |
| 650010 | Гэрээт ажилтан                                                                        | 04.00                 | 04.00                 | 0.00                 | 100.0%        |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт                                         | Төлөвлөгөө     | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|-----|--------------------------------------------------|----------------|-----------------------------|-----------------|------|
| 1   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |                |                             |                 |      |
| 2   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                | 497,995,100.00 | 497,993,465.30              | 1,634.70        | 100% |

|        |                                                   |                |                |                |        |
|--------|---------------------------------------------------|----------------|----------------|----------------|--------|
| 21     | УРСГАЛ ЗАРДАЛ                                     | 497,995,100.00 | 497,993,465.30 | 1,634.70       | 100%   |
| 210    | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                   | 497,995,100.00 | 497,993,465.30 | 1,634.70       | 100%   |
| 2103   | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал         | 481,495,100.00 | 481,494,915.30 | 184.70         | 100%   |
| 210301 | Гэрэл цахилгаан                                   | 7,348,000.00   | 10,291,558.30  | -2,943,558.30  | 140.6% |
| 210302 | Түлш, халаалт                                     | 458,716,900.00 | 469,101,742.00 | -10,384,842.00 | 102.2% |
| 210303 | Цэвэр, бохир ус                                   | 15,430,200.00  | 2,101,615.00   | 13,328,585.00  | 13.6%  |
| 2106   | Эд хогшил, урсгал засварын зардал                 | 0.00           | 0.00           | 0.00           |        |
| 210604 | Урсгал засвар                                     | 0.00           | 0.00           | 0.00           |        |
|        | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 497,995,100.00 | 497,993,465.30 | 1,634.70       | 100%   |
| 1310   | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                    | 497,995,100.00 | 497,993,465.30 | 1,634.70       | 100%   |
| 132001 | Орон нутгийн төсвөөс                              | 497,995,100.00 | 497,993,465.30 | 1,634.70       | 100%   |
| 4      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00           | 0.00           | 0.00           |        |
| 5      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00          | 00.00          | 0.00           |        |

## 2.7 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт                                         | /төгрөгөөр/ |               |
|------------|--------------------------------------------------|-------------|---------------|
|            |                                                  | Өмнөх он    | Гүйцэтгэл     |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |             |               |
| I          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                |             | 63,717,640.67 |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ                                    |             | 63,717,640.67 |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                  |             | 55,687,640.67 |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                |             | 3,203,547.27  |
| 210102     | Нэмэгдэл                                         |             | 3,203,547.27  |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл   |             | 400,443.40    |
| 210201     | Тэтгэврийн даатгал                               |             | 272,301.50    |
| 210202     | Тэтгэмжийн даатгал                               |             | 32,035.48     |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал                                |             | 16,017.74     |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал                             |             | 16,017.74     |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал                            |             | 64,070.94     |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                 |             | 4,901,050.00  |
| 210401     | Бичиг хэрэг                                      |             | 691,300.00    |

|             |                                                                                                             |  |                      |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|--|----------------------|
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал                                                   |  | 930,000.00           |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                                                 |  | 3,279,750.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                                                    |  | <b>14,725,000.00</b> |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                                                                                     |  | 4,239,900.00         |
| 210604      | Урсгал засвар                                                                                               |  | 10,485,100.00        |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                                                               |  | <b>4,728,200.00</b>  |
| 210702      | Дотоод албан томилолт                                                                                       |  | 4,728,200.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                                             |  | <b>9,517,200.00</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                        |  | 9,517,200.00         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                                      |  | <b>18,212,200.00</b> |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                                                             |  | 18,212,200.00        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                     |  | <b>8,030,000.00</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                                               |  | <b>8,030,000.00</b>  |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                                                     |  | 8,030,000.00         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                       |  | <b>63,717,640.67</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                          |  | <b>63,717,640.67</b> |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |  | 6,603,990.67         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  |  | 11,896,600.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                |  | 45,217,050.00        |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                                                             |  | <b>0.00</b>          |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                            |  | 0.00                 |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                           |  | 0.00                 |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Биеийн тамир, спортын газар нь идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох, спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх, тамирчдын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

Байгууллагын үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудыг дагаж мөрддөг.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 6-р дугаар сарын 05 -ны өдөр
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд -2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр,
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр,
- ✓ Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын 2, 10 дугаар хавсралт
- ✓ Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоол

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 352,630.6 мянган төгрөгөөр буюу 13.1 хувиар өссөн байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт       | Эхний үлдэгдэл | /мянган төгрөгөөр/ |          |
|----------------|----------------|--------------------|----------|
|                |                | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт |
| Б              | 1              | 2                  | 3=2-1    |
| Мөнгөн хөрөнгө | 0.0            | 0.0                | 0.0      |

|                                              |                    |                    |                   |
|----------------------------------------------|--------------------|--------------------|-------------------|
| Авлага                                       | 0.0                | 0.0                | 0.0               |
| Бараа материал                               | 47,076.4           | 52,472.1           | 5,395.7           |
| Үндсэн хөрөнгө                               | 2,639,708.9        | 2,479,878.9        | -159,830.0        |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>2,686,785.3</b> | <b>2,532,351.1</b> | <b>-154,434.2</b> |
| Өр төлбөр                                    | 39,352.4           | 54,768.0           | 15,415.6          |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 2,647,432.9        | 2,477,583.1        | -169,849.9        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>2,686,785.3</b> | <b>2,532,351.1</b> | <b>-154,434.2</b> |

Бараа материалын дансны үлдэгдэл 52,472.1 мянган төгрөг болж 5,395.7 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал 386.4 мянга, бусад хангамжийн материал 2,243.5 мянга, тусгай зориулалтын материал 480.0 мянга, аж ахуйн материал 2,285.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,479,878.9 мянган төгрөг болж, 159,830.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 54,768.0 мянган төгрөг болж, 15,415.6 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,477,583.1 мянган төгрөг болж 169,849.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 935,826.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 530,309.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,466,136.1 мянган төгрөгийн зардлыг 208,995.7 мянган төгрөгөөр бууруулж 1,257,140.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Дээрх баталсан төсвөөс 1,257,509.5 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 1,234,413.5 мянган төгрөгийн дутуу зарцуулж 23,096.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн нь төсвийг бодитой төлөвлөх шаардлага байгааг харуулж байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэх 759,145.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвийн санхүүжилтээр 497,995.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 759,145.3 мянга, орон нутгийн санхүүжилтээр 497,995.1 мянга, нийт 1,257,140.4 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,234,919.1 мянган төгрөгийг зарцуулж, нийт 22,221.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,234,919.1 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 19,284.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,370.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.2 мянга, хангамж, бараа материалын зардал 0.1 мянга,

урсгал засварын зардал 1.4 дотоод албан томилолт 48.5 мянга, бусад урсгал шилжүүлэг 1.5 мянга, бараа үйлчилгээний зардал 25.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 490.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ                           | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ |         |
|-----|-------------------------------------------------|------------|-----------|--------------------|---------|
|     |                                                 |            |           | Зөрүү              | Биелэлт |
| 1   | Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/           | 603,636.6  | 581,448.7 | 22,187.8           | 96.3%   |
| 2   | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111/   | 497,995.1  | 497,993.4 | 1.6                | 99.9%   |
| 3   | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал /80802 | 27,857.6   | 27,586.1  | 1.5                | 99.9%   |
| 4   | Биеийн тамирын уралдаан тэмцээн /80305/         | 90,704.7   | 90,685.2  | 19.5               | 99.9%   |
| 5   | Биеийн тамир спортын зардал /82106/             | 36,946.4   | 36,946.4  | 10.5               | 99.9%   |

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

| № | Үзүүлэлт                        | Гүйцэтгэл | /мянган төгрөг/                                                                                                                                                                                  |  |
|---|---------------------------------|-----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|   |                                 |           | Тайлбар                                                                                                                                                                                          |  |
| 1 | Ахмадын сан                     | -         | Ахмадын сангийн дансгүй байна.                                                                                                                                                                   |  |
| 2 | Худалдан авах ажиллагаа         | 70,461.9  | 2024 онд цахим худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин 9,928.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 60,533.0 мянган төгрөгөөр бараа материалыг тус тус шууд худалдан авалт хийсэн байна. |  |
| 3 | Төлбөр хураамжийн зардал        | 10,845.0  | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал-10,845.0 мянга                                                                                                                                               |  |
| 4 | Бараа үйлчилгээний бусад зардал | 147,522.5 | 80305 Биеийн тамирын уралдаан тэмцээн- 100,451.0 мянга<br>82106 Нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээн- 47,071.5 мянга                                                                          |  |
| 5 | Орон тоо                        |           | Батлагдсан бүтэц 23 орон тоотойгоор батлагдаж гүйцэтгэлээр 25 орон тоотой ажилласан байна.                                                                                                       |  |

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 11,896.6 мянга, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7,480.7 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 45,217.0 мянга, нийт 64,594.3 мянган төгрөгийн

нэмэлт санхүүжилт авч, гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 64,594.3 мянган төгрөгийг зарцуулж 876,7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ                 | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|-----|---------------------------------------|------------|-----------|----------|---------|
| 1   | Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/ |            | 53,582.0  | 53,582.0 | 99.9%   |
| 2   | Нийтийн биеийн тамирын зардал/82101/  |            | 10,135.0  | 10,135,0 | 100%    |

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Биеийн тамир, спортын газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хангамж бараа материалын зардал болох бичиг хэрэг, тээвэр шатахуун, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, тусгай зориулалтын материалд нийт 60,473.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор Г.Тунгалаг гүйцэтгэж анхан шатны хяналтыг захирал А.Дугармаа, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 01/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,194,485.1 мянган төгрөгөөс 1

хувиар буюу 11,944.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,491,584.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,915.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,932.6 мянган төгрөгөөр тогтоолоор.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.  
/АБ-4/

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаанд нь байршуулсан 68, хугацаа хоцроон байршуулсан 51, хугацаандаа мэдээлгүй 38, хугацаа болоогүй мэдээлэл 2 хүлээгдэж байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.3 Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

#### 1.1 Илрүүлэлт:

Увс аймгийн Биеийн тамир спортын газар нь 4,846.5 мянган төгрөгийн шатах, тослох материалыг зарцуулахдаа олгосон жагсаалт үйлдээгүй, замын хуудсыг дутуу хөтөлсөн, зарцуулалтын тооцоо бодоогүй байна.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг мөрдөж, цаашид жолоочийн замын хуудсыг бүрэн хөтөлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч<br>утга | /мянган төгрөгөөр/ |     |                                         |     |                             |     |            |     |              |     |         |     |
|----------------------|--------------------|-----|-----------------------------------------|-----|-----------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
|                      | Нийт алдаа         |     | Мэдээллийг<br>тусгахгүй<br>орхигдуулсан |     | Буруу тусган<br>илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |     | Зөвлөмж |     |
|                      |                    |     |                                         |     |                             |     | Загруулсан |     | Загруулаагүй |     |         |     |
|                      | Тоо                | Дүн | Тоо                                     | Дүн | Тоо                         | Дүн | Тоо        | Дүн | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
|                      |                    |     |                                         |     |                             |     |            |     |              |     |         |     |
|                      |                    |     |                                         |     |                             |     |            |     |              |     |         |     |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга          | Нийт зөрчил |         | Үүнээс        |  |                 |  |         |         |                                      |  |                                                 |  |
|-----------------------------|-------------|---------|---------------|--|-----------------|--|---------|---------|--------------------------------------|--|-------------------------------------------------|--|
|                             |             |         | Төлбөрийн акт |  | Албан шаардлага |  | Зөвлөмж |         | Хариуцлага тооцуулах албан шаардлага |  | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |  |
|                             | Тоо         | Дүн     |               |  |                 |  |         |         |                                      |  |                                                 |  |
| Замын хуудас дутуу хөтөлсөн | 1           | 4,846.5 |               |  |                 |  | 1       | 4,846.5 |                                      |  |                                                 |  |
|                             |             |         |               |  |                 |  |         |         |                                      |  |                                                 |  |
| Дүн                         | 1           | 4,846.5 |               |  |                 |  | 1       | 4,846.5 |                                      |  |                                                 |  |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч<br>утга                                    | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |     |
|----------------------------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|                                                          |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|                                                          | Тоо         | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |     |               |     |                 |     |         |     |
| байхгүй                                                  |             |     |               |     |                 |     |         |     |
| Дүн                                                      |             |     |               |     |                 |     |         |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |     |               |     |                 |     |         |     |
| байхгүй                                                  |             |     |               |     |                 |     |         |     |
| Дүн                                                      |             |     |               |     |                 |     |         |     |
| Нийт дүн                                                 |             |     |               |     |                 |     |         |     |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ  
ХХК-ийн ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ  
ХХК-ийн ТУСЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/А.ДУГАРМАА/

/Г.ТУНГАЛАГ/

2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр